



утга соёлын “морин” хүлгийн эзэн насанхишигийн Баярын эрдмийн аяны дөрөөнд сүүний дээж өргөн мялаахын учир

Монголчуудын оюуны соёлд эртний уламжлалт хулэг морины тухай үзэл санаа нэн тодорхой байр эзэлдэг бөгөөд “Морины соёл” хэмээн нэрлэж болох цогц том ойлголтыг хэдийнээ бүрдүүлжээ. Монгол морь, нүүдэлчин удмын монгол дайн эр хоёр салгахын аргагүй нягт ойлголт ухагдахуун болон цогцлон байна.

Хэлбичгийн шинжлэх ухааны доктор /Sc. d/ Н. Баярын уншигч танаа толилуулан буй эл бүтээл зан үйлийн аман зохиолын төрөлд хамаарах дом шившлэг, хараал зүхэл, цээр ёс, тайлга, тахилгын шүлэг, ерөөл магтаалаас аваад монгол баатарлагийн тууль, үлгэрийн төрөлд туссан морины дүрийг нарийвчлан судлаад “Тууль дахь хүн морины дүр үргэлж хүслэнчилсэн дүрээр илэрдэг бөгөөд хоорондоо төгөлдөр байдлаар нэгдэж нэг зүйлийн онцгой соёл сэтгэхүйн загварчлалаар цогцолсон юм” гэх мэтчилэн хэд хэдэн сонирхолтой шинэлэг дүгнэлт хийжээ. Үнэндээ монгол тууль үлгэрт гардаг хулэг морь бол жирийн нэг адгуус бус заримдаа хүний хэлээр ярьж баатар эрийн мартсаныг сануулж дайсныг дарах арга замыг ч хүртэл сүвэгчлэн эзэндээ зааж өгдөг үлэмж ухаантай байдлаар дүрслэгдсэн байдаг. Ийм учраас хүнээс ухаантай хулэг морь дүрслэгдсэн нь үнэхээр хүслэнгийн агуулга утгаар тайлбарлагдана. Монгол аман зохиол дахь морины өгүүлэмжид адгуулах, маллах, тоног хэрэгсэл малчны эрдмийн тухай цогц ойлголтыг багтаан морины соёлд хамаарах эрдэм ухааны олон салбарын мэдлэг, гоо сайхны ойлголт, уламжлалт зан үйл, ёс заншил цогцолсон байдаг.

Дэлхийн улс түмэн бүгд өөрсдийн оршин суугаа газар нутаг, эрхэлдэг ажил төрөл, угсаа гарал, түүх соёлоос хамааран тус бүртээ онгон шүтээн болгосон амьтдын сахиусан дүртэй билээ. Тэгвэл жилийн дөрвөн улирал





солигдон уул хангай, тал хээр, элст говь ээлжилсэн өргөн уудам нутагтаа эрт үеэс нүүдлийн мал аж ахуй эрхлэн аж төрж ирсэн монголчуудын уламжлалт морины соёл нь эдүгээгийн даяаршлын шуугиант эрин үед хүлгийн үүрсэх, морины янцгаах дуун мэт тодын тод агаад хоёрхон чавхдсанд хорвоогийн хамаг явдлыг багтаан дуурьсадаг морин хуурын аялгуу мэт эгшиглэнтэй сонсогдном.

Монголчууд морин хуур эгшиглүүлбэл гэрийн жавар арилна гэж бэлгэшээдэг. Тэгвэл морины соёл нь даяаршлын эриний сайн бүхнийг утган саар муу жаврыг арилгахад тодорхой үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Учир нь монгол түмэн мал сүрэгтээ элэгсэг дотно ханддаг төдийгүй аман зохиол дахь хүншүүлсэн морины дүрээр хүн хүндээ төдийгүй сахиус шүтээндээ хүндэтгэлтэй хандах харьцааг илэрхийлсэн байдаг.

Монгол түмний морины соёлын тухай өгүүлсэн утга соёлын “морин” хүлгийн эзэн Насанхишигийн Баярын алсыг зорисон эрдмийн аяны дөрөөг ХХ зууны Монголын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн “Хүлэг минь, шүлэг минь” шүлгийн:

Хүлэг минь шүлэг минь хурдлан давхи

Хүлгийн шандас харуулахад холын зай хэрэгтэй

Хүн ардынхаа захиасыг санан санан давхи

Хүлэг бид хоёрт дэлхийн дэвжээ хэрэгтэй

хэмээсэн утга гүн, уран яруу үгсээр морины соёлыг судлан шинжлэх үйлсэд тань сайн бүхнийг ерөөн бэлгэдсэн сэтгэлийн сүүн цацал өргөө!

Монгол улсын ШУА-ийн академич, доктор

/Sc. d/, профессор Х. Сампилдэндэв.

Х. Сампилдэндэв

2005. 5. 23



מקורות המסמך (124)

מקורות המסמך (94)

מקורות המסמך (80)

מבנה המסמך (79)

מקורות המסמך (62)

מקורות המסמך (44)

מקורות המסמך (40)

מבנה המסמך (39)

מקורות המסמך (30)

מקורות המסמך (24)

מקורות המסמך (23)

מקורות המסמך (1)





יְהוָה יִמְצָא..... (313)

לְהַגְדִּילָהֶם..... (303)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (285)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (256)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (238)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (237)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (217)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (196)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (189)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (183)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (173)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (156)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (136)

וְהַשְׁמִיעַ לָהֶם קוֹלִי וְהַשְׁמַע לָהֶם קוֹלִי..... (135)



